



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2020 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 41

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дулааны гуравдугаар цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 4 нэрийн 301,277,038.19 (гурван зуун нэгэн сая хоёр зуун далан долоон мянга гучин найман төгрөг арван есөн мөнгө) төгрөгийн балансын үнэ, 284,323,204.41 (хоёр зуун наян дөрвөн сая гурван зуун хорин гурван мянга хоёр зуун дөрвөн төгрөг дөчин нэгэн мянган) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Батгэрэл, “Дулааны гуравдугаар цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ч.Чинбат, “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн захирал Ү.Төмөрхуяг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэст үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ



0000051

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2020 оны 02 дугаар сарын 11-ны өдрийн  
 4/... дугаар тогтоолын хавсралт

**"ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИАС "ДУЛААНЫ ДӨРӨВДҮГЭЭР  
 ЦАХИЛГААН СТАНЦ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Автомашинны марк, улсын дугаар, арал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Ялгах блок №2/ пульт №2 хамт/	Ком	1.00	105,776,018.30	100,968,017.71	4,808,000.59
2	Цэвэрлэх блок №2	Ком	1.00	158,414,708.81	158,414,708.81	-
3	Феронон хөргөх төхөөрөмж/ урьдчилан хөргөх аппарат/	Ком	1.00	15,086,311.08	15,086,311.08	-
4	Насос/ НЖ-0.025/20 хөдөлгүүрийн хамт/	Ком	1.00	22,000,000.00	9,854,166.81	12,145,833.19
<b>Нийт дүн</b>				<b>301,277,038.19</b>	<b>284,323,204.41</b>	<b>16,953,833.78</b>
				(гурван зуун нэгэн сая хоёр зуун далан долоон мянга гучин найман төгрөг арван есөн мөнгө)	(хоёр зуун наян дөрвөн сая гурван зуун хорин гурван мянга хоёр зуун дөрвөн төгрөг дөчин нэгэн мөнгө)	(арван зургаан сая есөн зуун тавин гурван мянга найман зуун гучин гурван төгрөг далан найман мөнгө)